



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 1149

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгө буюу
биет бус үндсэн хөрөнгөд бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Газрын дүрмийн 7.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 47 тоот гэрээгээр “Брэв Нью Медиа” ХХК-ний хийж гүйцэтгэсэн нийт 5,000,000 (таван сая) төгрөгийн үнэ бүхий “Визит Улаанбаатар” аппликейшныг байгууллагын эргэлтийн бус хөрөнгө буюу биет бус үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлд бүртгэж авахыг Ахлах нягтлан бодогч (Д.Уянга), нярав (М.Мөнх-Эрдэнэ)-д нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500304